ВИДЕО МЭДЭЭ · 2023 оны 1-р сарын 6

Про подкаст №108 ПРОКУРОР ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХЭРХЭН ХАНГАЖ АЖИЛЛАДАГ ВЭ?



УЕПГ-ын Олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн Б.Будхүү УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор О.Баярсайхантай "Прокурор ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хэрхэн хангаж ажилладаг вэ?" сэдвээр ярилцлаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд прокурорын байгууллагын чиг үүргийн "Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэж тодорхойлсон.

Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлд прокурор ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихдаа:

- Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;

- Ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн эсэх;

- Ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх;
- Баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэхийг хянана гэж заасан.

Видео: https://www.youtube.com/watch?v=StvqwLr0zt4

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2086